



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 3 дугаар
сарын 2-ны өдөр

Дугаар 70

Улаанбаатар
хот

Хөрөнгө гаргах тухай

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 8.3.7, Төсвийн тухай хуулийн 47.1.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хэвийн ажиллагааг хангах, зайлшгүй шаардлагатай харилцаа холбооны үйлчилгээг алслагдсан орон нутагт болон үйлчилгээ хүрээгүй хүн амд хүргэх төсөл, арга хэмжээний зардалд шаардагдах 3.5 (гурван тэрбум таван зуун сая) тэрбум хүртэлх төгрөгийг 2013 оны төсөвт тодотгол хийх хүртэл хугацаанд Засгийн газрын нөөц сангаас олгохыг Сангийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

2. Засгийн газрын нөөц сангаас олгосон санхүүжилтийг зориулалтын дагуу зайлшгүй шаардлагатай харилцаа холбооны үйлчилгээг орон нутагт болон үйлчилгээ хүрээгүй хүн амд хүргэх, харилцаа холбооны сүлжээг өргөтгөх, шинэчлэх, шинээр байгуулахад үр ашигтай зарцуулахыг Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын дарга Ц.Жадамбаа, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэг нарт тус тус даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Сангийн сайд

Н.АЛТАНХУЯГ

Ч.УЛААН